



Сонгуулийн хөтөлбөр

ӨНӨӨДРИЙН ДАРАМТЫГ ХАЛНА
ӨРХ ГЭРИЙГ ТЭТГЭНЭ

Өмнөх үг.....	2
Нэг. Өрх гэрээ тэтгэе	3
1. Ирээдүй сан, Итгэлийн мөнгө.....	3
2. Орон сууц, ипотек	3
3. Газар өмчлөл, үл хөдлөх хөрөнгө	4
Хоёр. Нийгмийн бодлого, шинэ хандлага	5
4. Боловсрол, соёл иргэншил.....	5
5. Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал.....	6
6. Дэг журам, гэмт хэрэг.....	7
Гурав. Захиргаадалтын дарамтыг арилгая.....	7
7. Улс төр, эрх зүй	7
8. Мэргэшсэн алба, төрийн үйлчилгээ.....	8
9. Бодит мэдээлэл, эрх чөлөө	9
Дөрөв. Бизнесийг дарамтаас чөлөөлье	10
10. Өрсөлдөх чадвар, шударга орчин	10
11. Бүтээн байгуулалт, эрчимтэй хөгжил.....	12
12. Мөнгө, санхүү.....	13
13. Ажил эрхлэлт, эрх тэгш харилцаа	14
14. Байгаль орчин, тулхтай хөгжил	15
Тав. Даяаршсан ертөнцөд итгэлтэй амьдарцгаая.....	16
15. Тэнцвэртэй, давшингүй гадаад бодлого	16
16. Зэвсэгт хүчин, аюулгүй байдал	17

“ЭХ ОРОН АРДЧИЛАЛ” ЭВСЭЛ

Өмнөх үг

Ардчилсан хүчний санаачилга, зүтгэлээр сүүлийн арав гаруй жилд ардчилал, зах зээл манай оронд нутагшиж Монголчуудын улс төрийн амьдралд ахиц гарлаа. Монголчууд төр улсын хэргээ өөрсдөө шийдвэрлэдэг болж, улс төрийн тусгаар тогтнолыг жинхэнэ утгаар олж авсан юм. Нийгэм, эдийн засгийн салбарт Монгол улс улам бүр бие дааж, монголчууд хүний эрхээр жаргахаар өөрийн эрхээр зовдог боллоо. Гэвч ардчилал, зах зээлийн нөхцөлд бүтээгдэж байгаа нийгмийн баялаг шударга хувиарлагдахгүй цөөн хэсэг нь хэт их баяжиж эгэл жирийн хүмүүс ядуу хэвээр байна.

Хээл хахууль, хүнд суртал олон түмний өдөр тутмын дарамт болж, нийгмийн ёс суртахууныг унагаж, улс гүрний хөгжлийн тушаа болж байна. Хөрөнгө мөнгө цөөн хүмүүсийн гарт төвлөрч, төр засаг олон түмэнд улам бүр үйлчлэхээ больж байна. Ард түмний оюун санааг хуучны үзэл, хүнд суртлаар дарамтлах, сэтгүүлчдийг айлган дарамталж, үг хэлэх эрх чөлөөг боймлох, нийгмийг айдас хүйдэст автуулж, ард түмнийг хүлцэнгүй, идэвхгүй байдалд оруулах үйл ажиллагаа явагдаж, нийгэмд шударга ёс алдагдаж байна.

Ийм нөхцөл “Эх орон-ардчилал” эвсэл нэгдсэн улс төрийн намууд, түүний мянга мянган гишүүд, дэмжигчид - Бид нийгмийн цоо шинэ бодлого хэрэгжүүлэх болно. Өрх гэрийн ахуй амьдралыг сайжруулах, хүүхдээр дамжуулан гэр бүлийг дэмжих нийгмийн цоо шинэ бодлого дэвшүүлж байна.

Бид 18 хүртэл насны бүх хүүхдэд сар бүр арван мянган төгрөгийн “Итгэлийн мөнгө” олгох болно. Энэ нь нийгмийн баялгийг шударга хуваарилах, ард түмний олонхийн өдөр тутмын дарамтыг зөөллөх, ирээдүйдээ итгэлтэй амьдрахад түлхэц болно гэж үзэж байна.

Дээрх гол зорилтыг биелүүлэхийн тулд эдийн засаг, нийгмийн салбарт олон тооны хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 1996-2000 онд эхлүүлсэн болон 2000-2004 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг хавсралт 1-ээс үзнэ үү.

Нэг. Өрх гэрээ тэтгэе

1. Ирээдүй сан, Итгэлийн мөнгө

Ахмадаа хүндэтгэсэн, залуучуудаа дэмжсэн, хүүхдүүдээ тэтгэсэн таатай харилцааг нийгэмд бүрдүүлэх нь эх орны хөгжил цэцэглэлтэд ихээхэн тус дэм болно. Энэ зорилтын хүрээнд монголын ирээдүй болсон үр хүүхдээ төрөөс тэтгэх явдал чухал байна. Бүх хүүхдэд сар бүр “Итгэлийн мөнгө” олгосноор нийгэм дэх орлогын тэгш бус хуваарилалтыг арилгах, ядуурлыг бууруулах, залуу гэр бүлийг дэмжих, эцэг, эх хүүхдийн хоорондын харилцааг бэхжүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Шинэ Засгийн газрын эхний зуун хоногт багтааж холбогдох хууль, журмыг гарган “Итгэлийн мөнгө” олгох ажлыг зохион байгуулж эхлүүлнэ.

Залуу гэр бүлд зориулсан үл хөдлөх хөрөнгийн зээлийн тогтолцоо бүрдүүлнэ.

Өрхийн амьжиргааг дэмжих зорилгоор хүн амын орлогын албан татварыг өрхийн нэг хүнд ногдох орлогын хэмжээнээс хамааруулан ногдуулах шинэ зарчимд шилжих, энэ үндсэн дээр нийгмийн халамж, үйлчилгээний тогтолцооны шинэчлэл хийх болно.

2. Орон сууц, ипотека

Өрх бүр орон сууцтай болох нь ард түмний хэрэгцээ. Өрх бүрийг орон сууцтай болгох нь төрийн хэрэгцээ. Энэхүү хэрэгцээгээ хангахад нь хүн бүрт туслахыг бид хүсч байна. Үүний тулд Эвслээс “40 мянган орон сууц” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Хөтөлбөр хэрэгжүүлснээр сууцны үнэ буурах болно. Орон сууцны үндэсний бодлогыг цэгцлэн хот байгуулалт, татвар, гаалийн бодлогоор дэмжин барилгын материал, зураг төслийн зардлыг багасгах болно. Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ. Урт хугацааны хөнгөлөлттэй зээл авч орон сууц худалдан авах явдлыг урамшуулах болно. Орон сууцны санхүүжилтийн банк байгуулна.

Дунд болон бага орлоготой өрхөд барих орон сууцаар нь барьцаалж урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох мөнгө, санхүүгийн бодлого явуулах, энэ талаар төрөөс үзүүлэх дэмжлэг, туслалцааны тухай хууль гаргана. Барьцаалан зээлдэж орон сууц худалдаж авах явдлыг (ипотека) ажилчиддаа санал болгож буй байгууллагуудыг дэмжих болно. Банк, санхүүгийн байгууллагуудыг ипотекийн харилцаанд орох явдлыг урамшуулна. Чинээлэг амьдрахын тулд гэр ахуйгаа дэвшилт технологиор шинэчлэх таатай нөхцөл

бүрдүүлнэ. Байгалын хийг ахуйд хэрэглэх чиглэлээр төсөл боловсруулж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.

Цэвэр, бохир усны болон дулааны шугам сүлжээнд холбогдох явдлыг чирэгдэл багатай болгож эдгээр үйлчилгээг өргөтгөх нөхцөлийг бүрдүүлнэ. Дулаан, цэвэр ба бохир ус, цахилгаан шугам сүлжээнд дэвшилтэт, хэмнэлттэй тоноглолуудыг нэвтрүүлэх замаар нэмэгдэл хэрэгцээг хангахад анхаарна. Хэрэгцээний усанд ариутгал, шүүлтүүрийн хамгийн сүүлийн үеийн шилдэг техник технологийг хэрэглэх явдлыг дэмжиж, нийтийн орон сууцны компаниудаас усны шүүлтүүр тавих ажилд нь туслана. Усны хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарна.

Гэр хороололд амьдрагчид орон сууцаа сайжруулж цэвэр бохир ус, цахилгаан, байгалийн хийгээр хангагдах нөхцлийг бий болгоно. Ариутгаж савласан цэвэр усанд лабораторийн хяналт хийх ажлыг тогтмолжуулж үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэл баримтална. Рашаан усны хангалт, экспортыг нэмэгдүүлэх чиглэлийн бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллана. Сэргээгдэх эрчим хүч болон ердийн цахилгаан эрчим хүч ашиглан халаалт, халуун усны асуудлыг шийдвэрлэх технологийг өргөнөөр хэрэглээнд оруулна. Бохир усны цэвэрлэгээ, ариутгалд стандартын шаардлагыг чанд мөрдүүлнэ.

3. Газар өмчлөл, үл хөдлөх хөрөнгө

Иргэн бүрт газар өмчлүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулна. Хувийн өмчийн газрыг бие даасан чөлөөт амьдралын эх сурвалж болгоно. Тухайн нутаг дэвсгэрт бизнес эрхлэхэд дөхөмтэй дэд бүтэц, зах зээлд ойр газрыг иргэдэд өмчлүүлэнэ. Шинээр өмчлүүлэх газруудад ус, гэрэл цахилгаан, нийтийн үйлчилгээг бий болгоход төрөөс дэмжлэг үзүүлнэ. Эзэмшлийн газрыг хувийн өмчлөлд шилжүүлэх ажлыг явуулна. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд тодорхой нутаг дэвсгэрт мод тарих, ойжуулах замаар тухайн газар нутгийн чанарыг сайжруулж өмчлөх, эзэмших, ашиглах явдлыг дэмжинэ.

Нийтийн эдэлбэрийн болон бэлчээрийн талбайн газрын зохион байгуулалтыг шинэчлэн хийж иргэдэд өмчлүүлэх эдийн засгийн ач холбогдолтой газрын санг нэмэгдүүлнэ. Газрын кадастрын зураглал үйлдэхэд гарч буй хүнд суртлыг арилгана. Газар өмчлөлийн мэдээлэл бүртгэлийг иргэдэд нээлттэй байлгаж, үйлчилгээг шуурхай болгоно.

Хот төлөвлөлт, архитектурын ажилд тавих ИТХ-ын хяналт шалгалтын ажлыг сайжруулж, тухайн нутаг дэвсгэрийн Сууц өмчлөгчдийн холбоо, иргэдийн (ТББ) оролцоог нэмэгдүүлнэ. Богд уулын хормой, Туул, Сэлбэ

голын дагуу нийтийн зориулалттай цэцэрлэг, амралтын орчин бүрдүүлэхэд тодорхой хөрөнгө зарцуулна.

Хоёр. Нийгмийн бодлого, шинэ хандлага

4. Боловсрол, соёл иргэншил.

Боловсролын тогтолцоонд өрсөлдөөн бий болгох замаар боловсролыг бүхэлд нь ардчилж, чанарыг нь сайжруулна.

Ерөнхий боловсролын сургуулиудад анги дүүргэлтийн тоог хязгаарлах замаар багш нарын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, багш нараас сурагчидаа тавих анхаарлыг нэмэгдүүлэн сургалтын чанарыг сайжруулахад анхаарна.

Англи хэлний сургалтыг албан ёсоор дунд сургуулийн хөтөлбөрт оруулж, зориулалтын сурах бичиг хэвлэх, багшлах бүрэлдэхүүнийг бэлтгэхэд хөрөнгө оруулалт хийнэ.

Мэргэжлийн дипломын боловсролыг зөвшөөрөх, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрлөх эрхийг харилцан зөвшөөрөлцөх гэрээ хэлэлцээрийг сонирхсон орнуудтай байгуулж хэрэгжүүлнэ. Иргэдийн мэргэжил, мэргэшлийг дээшлүүлэх сургалтуудыг өргөнөөр зохион байгуулж гадаад улс орнуудад явж ажиллах явдлыг дэмжиж, олон улсын яриа хэлэлцээнд санаачилгатай, идэвхтэй оролцоно.

Их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрийг практик мэдлэгт чиглүүлэн шинэчлэл хийнэ. Дотоодын их дээд сургуулиудаас оюутнууд шалгаруулж төрийн зардлаар гадаадад сургана. Оюутнуудад зориулан оюутны байр, хотхон байгуулж ашиглалтанд оруулах санаачилгыг дэмжинэ. Оюутны эрүүл мэндийн даатгалыг төр хариуцна.

Ажил хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ суралцах хүсэлтэй хүмүүст зориулсан “олон нийтийн нээлттэй их сургууль”-ийг байгуулж ажиллуулна. Энэ нь томоохон их, дээд сургуулиудын хамтарсан хөтөлбөр хэлбэрээр хэрэгжих болно. Алсын зайны сургалтыг өргөнөөр ашиглах бөгөөд интернэтийг боловсрол олгох ажлын гол хэрэгсэл болгоно.

Шинжлэх ухааны академийн үйл ажиллагааг эрчимжүүлэн олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай холбож, судалгаа шинжилгээний ажлыг тэргүүний технологийг нутагшуулах, үндэсний эдийн засгийг хөгжүүлэх, хүн амын амьдралын чанарыг сайжруулах зорилгод чиглүүлнэ.

Монголын түүхийн судалгааг хийх ажлыг эрчимжүүлэн хөгжүүлж, бусад орны номын сан, архив зэргээс үнэт материалыг солилцоогоор болон хуулбарлан авах ажлыг санхүүжүүлнэ.

Мэргэжлийн сургалтад онцгой анхаарна. Нарийн мэргэжлийн сургалтын тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлж ажлын байр шинээр бий болгох зорилт дэвшүүлж байна. Ажилгүйчүүдэд мэргэжил дадлага олгох сургалтыг зохион байгуулж шинээр ажилд орсон залуучуудад гарааны зээл, тусламж өгөх байгууллагуудын идэвх санаачилгыг дэмжих болно. Хөдөлмөр зуучлалын албад, компаниудад төрийн байгууллагуудтай гэрээ байгуулан өөрөө өөрийгөө санхүүжүүлэх хэлбэрээр ажиллах боломжийг олгох болно. Ажилгүй хүмүүст ажил хөдөлмөр эрхлэх бололцоог олгох зорилготой сургалтын албуудын үүсэх, үйл ажиллагаагаа явуулахад нь туслалцаа үзүүлнэ. Үйлдвэр, аж ахуйн газруудад үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр, эрүүл ахуйн стандартыг чанд мөрдүүлнэ.

5. Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хүн бүрт адилгүй байна. Өнгөрсөн хугацаанд эрүүл мэндийн салбарын зах зээлийн харилцаанд шилжих явц ухралтад орлоо.

Энэ салбарт хувьчлалыг тохиромжтой аргуудаар хийх, хувийн эмнэлэгүүд, оношлогооны төвүүд байгуулах санаачилгыг дэмжинэ. Монгол хүн эх орныхоо аль ч хэсэгт эмчилгээ, үйлчилгээнд саадгүй хамаарагдах нөхцлийг бүрдүүлнэ. Эмч, сувилагчдыг шаардлагагүй зөвшөөрөл, лицензийн дарамтаас чөлөөлнө.

Хувийн эрүүл мэндийн даатгалыг урамшуулна. Нарийн мэргэшлийн эмч нарыг гадаад оронд мэргэшүүлэх, өндөр үнэтэй нарийн ажиллагаатай мэс заслуудыг дотооддоо хийдэг болгоход анхаарна. Эх нялхсын эрүүл мэндэд онцгой анхаарна. Бүс нутгийг хамарсан орчин үеийн эмчилгээ, оношлогооны сүлжээг бий болгоно. Мэргэшсэн сувилагчдыг бэлтгэх сургалтанд анхаарч олон улсын шаардлага хангахуйц мэргэжилтний тоог нэмэгдүүлнэ.

Нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийг улсын төсвийн орлого, зарлагад хамааруулж, төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах нь нийгмийн хамгааллыг эрсдэлд байгаа учраас энэ үйл үйл ажиллагааг зогсоож, төр зөвхөн дээрх сангуудыг даатгалд авах нь зүйтэй гэж үзнэ.

Өндөр настны нийгмийн хамгаалалыг сайжруулахын зэрэгцээ тэднийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулахад анхаарах болно. Нэг гэр бүлийн тэтгэвэр авагчдын Хамтарсан тэтгэвэрийн тогтолцоог нэвтрүүлнэ. "Ахмадын уулзалтын төв"-үүдийг байгуулан ажиллуулж ахмад настнуудыг

нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах замаар биеийн болон сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэхэд нь туслана.

Тахир дутуу иргэдэд болон сонсгол, харах чадвар муутай иргэдэд үзүүлэх төрийн туслалцааг нэмэгдүүлнэ. Тахир дутуу хүмүүст зориулсан тусгай хэрэгслийн үйлдвэрлэлийг орлогын татвараас чөлөөлнө.

6. Дэг журам, гэмт хэрэг

Өрх гэрийн амгалан тайван, баталгаатай байх явдал нийгмийн шинэ бодлогын чухал хэсэг байх болно.

Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урдчилан сэргийлэх талаар ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлж, тэдний хамтын ажиллагааг хөгжүүлэн энэ асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

Орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын мэдэлд байгуулагдах цагдаагийн албыг дэмжих болно. Цагдааг улс төрийн явцуу эрх ашигт ашигладаг явдлыг зогсооно. Гэрээт харуул хамгаалалт, хувийн бие хамгаалалтын байгууллагуудтай харилцан хамтарч ажиллах механизмыг боловсронгуй болгоно.

Хээл хахуулийг устгаж, гэмт этгээдүүдэд хуулийн дээд хэмжээ хүртэл шийтгэл ногдуулдаг болгоно. Авилгалтай хийх тэмцлийг эрчимжүүлж, арга барилын шинэ түвшинд гаргана. Авилгал авсан албан тушаалтанд хуулийн хатуу цээрлэл үзүүлдэг болгоно. Албан тушаалтнуудын орлогын мэдүүлгийг олон нийтэд нээлттэй мэдээлэх, хяналт хийх тогтолцоог бий болгоно. Авилгалтай тэмцэх тусгай албыг байгуулан ажиллуулна.

Гурав. Захиргаадалтын дарамтыг арилгая

7. Улс төр, эрх зүй

Хувьсгалт намын дарангуйллын дарамтаас ангижирч улс төрийн бүх хүчнүүд улс орондоо иргэний нийгмийг бэхжүүлж улс орноо хамтарч хөгжүүлэх явдал нь эвслийн үндсэн зорилго байх болно. Харьцангуй хүчтэй цөөнх бүхий тэнцвэртэй парламент үр дүнтэй ажиллах нөхцлийг Эвсэл бүрдүүлнэ.

Парламентын ардчиллыг бэхжүүлж, Засгийн газрын хариуцлагыг дээшлүүлнэ. Ерөнхий сайд долоо хоног бүр өөрийн биеэр болон салбар

хариуцсан сайдын хамтаар Улсын Их хуралд мэдээлэл өгдөг болгоно. Хүндлэлийн дээдийг хүн бүрт үзүүлэх нийгмийн ёс суртахууны номлолыг дэлгэрүүлнэ.

Төрийн болон төрөөс санхүүждэг нийтлэг үйлчилгээний байгууллагуудын зүгээс иргэдийн эрх ашиг сонирхлыг зөрчсөн үйлдэлтэй тэмцэх омбудсмэны албыг байгуулж ажиллуулна. Гадаадад байгаа иргэдийнхээ сонгох, сонгогдох эрхийг хангана.

Одоогийн засаг захиргааны хуваарийг нягтлан үзэж аймаг сумуудыг нэгтгэх, томсгох ажлыг хийх болно. Ингэснээр төрийн нийтлэг үйлчилгээг иргэдэд шуурхай бөгөөд элдэв шат дамжлагагүй хүргэх нөхцлийг бүрдүүлнэ.

Өмгөөлөгчдийн байгууллагыг хууль тогтоох засаглалын байгууллагаас албан ёсны эрх авдаг журмыг тогтооно.

Маргаан мэтгэлцээнийг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх арбитрын үйлчилгээг иргэд хоорондын маргаанд өргөн ашиглана. Маргаан зохицуулах туршлагатай шударга хуульчдад өөрсдийн маргаан зохицуулах үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй явуулах бололцоог олгож өгнө.

Шүүх эрх мэдлийн байгууллагуудын ажилд шударга ёс, хууль эрх зүй хатуу мөрдөгддөг байхыг шаардаж ажиллана. Хүний эрхийг хангах бүх талын нөхцлийг бүрдүүлж, тууштай хэрэгжүүлнэ.

8. Мэргэшсэн алба, төрийн үйлчилгээ

Төрийн албыг ганц намынх болгосон гажуудлыг арилгаж, мэргэжлийн ур чадвартай албан хаагчид тогтвортой ажиллах төрийн захиргааны мэргэшсэн албыг төлөвшүүлнэ. Төрийн албан хаагчдыг намын харьяалалгүй болгоно. "Электрон засаглал" хөтөлбөр хэрэгжүүлж төрийн байгууллагуудын ажилд тоон мэдээллийн системийг нэвтрүүлж шуурхай байдлыг хангана.

Төрийн албанд танил тал, хамаатан саднаараа нэг удирдлагын дор ажиллаж хууль завхруулдаг явдлыг таслан зогсооно. Төрийн албаны мэргэшлийн хяналтыг сайжруулна. Төрийн захиргааны албан хаагчдыг гадаад улс оронд олноор явуулж ижил төстэй байгууллагуудын туршлагаас суралцуулна. Мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамруулна. Төрийн захиргааны албанд ажиллагчид тангараг өргөж ажиллахын зэрэгцээ хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр тогтвортой ажилладаг байх нөхцлийг бүрдүүлнэ.

Бичиг баримт, тодорхойлолт, маягтуудыг электрон хэлбэрт оруулж төрийн нийтлэг үйлчилгээ, бүртгэл, зөвшөөрлийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлдэг болгоно. Төрийн байгууллагуудын ажил үйлчилгээг шуурхай

болгож, хүн хүчний давхардлыг арилгаж, ажлын ачааллыг нь жигдрүүлнэ. Электрон, тоон мэдээллийн технологийн хэлбэрээр иргэдэд бүх төрлийн мэдээлэл үйлчилгээг үзүүлдэг болгоно.

Төрийн үйлчилгээний онцлогт тохирсон маягтыг электрон болон хэвлэмэл байдлаар бэлтгэж төрийн үйлчилгээтэй холбоотой гаргасан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай бүртгэж зохих хариуг өгч байна. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн ажлыг электрон хэлбэрт оруулна.

Төрийн бүх байгууллагуудын ажилд электрон тоон мэдээлэл, интернэт ба дотоод мэдээллийн сүлжээг ашиглах болно. Монголын хот суурин газрын болон бусад бүх иргэдэд имэйл хаяг нээж уг хаягаа өөр хоорондоо харилцах хэрэгсэл болгох болно. Үүний тулд харилцаа холбоо, шуудангийн үйлчилгээг электрон мэдээллийн баазтай холбож ажиллуулах болно. Төлбөр тооцоог электрон хэлбэрээр хийх байгууллага иргэдийг урамшуулах болно.

Шуудангийн албыг төрийн үйлчилгээний албаны зэрэглэлд оруулж бүх төрлийн үйлчилгээ, төлбөрийн хэрэгсэл дамжуулах найдвартай суваг болгоно. Аймаг сумдад буй иргэдэд очих электрон захидлыг бусдад мэдэгдэлгүйгээр хэвлэж битүүмжилдэг програм, техник хэрэгслийг өргөнөөр нэвтрүүлнэ. Шуудан холбооны үйлчилгээг тоон мэдээллийн технологитой нягт уялдуулж, үйлчилгээний хэлбэр, цар хүрээг нэмэгдүүлнэ.

9. Бодит мэдээлэл, эрх чөлөө

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нийт иргэдийн хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцэж тэдэнд үйлчилдэг байх шударга шаардлагыг хэрэгжүүлнэ.

Үндэсний телевиз, радиог төрийн хяналтаас гарган бие даасан байдлыг хангана.

Иргэдэд үнэн бодитой, эрэлт хэрэгцээтэй мэдээлэл өгөхөд нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад туслана. Сэтгүүлчдийг мэргэжлийн ажлаа хийснийх нь төлөө мөрдөж, мушгих явдлыг таслан зогсооно.

Иргэдэд төрийн байгууллагын үйлчилгээтэй холбоотой мэдээллийг шуурхай нээлттэй хүргэх нөхцлийг бүрдүүлнэ. Тоон мэдээллийн технологид суурилсан телевизийн сувгаар дамжуулан орчин үеийн бүхий л төрлийн мэдээлэл, сургалт явуулах нөхцлийг бүрдүүлнэ. Хиймэл дагуулын харилцаа холбоог өргөнөөр ашиглаж сувгийн ашиглалтанд чөлөөт өрсөлдөөнийг нэвтрүүлнэ.

Дөрөв. Бизнесийг дарамтаас чөлөөлье

10. Өрсөлдөх чадвар, шударга орчин

Төр, бизнесийнхэн байр суурь бодлогоо солилцох, харилцан ойлголцлыг бий болгох, улс үндэснийхээ эрх ашгийн үүднээс харилцан үүрэг хүлээн хуулийн хүрээнд шударга ажиллах механизмыг төлөвшүүлнэ.

Элдэв лицензи зөвшөөрлийг устгаж, бизнес эрхлэх эрх чөлөөг бүрэн хангаж эдийн засгийн өсөлтийг жилийн 6-10 хувьд хүргэнэ. Лиценз, зөвшөөрлийг зориуд богино хугацаатайгаар олгож, дахин дахин сунгах, зах зээлийн зүй тогтлоор шийдэгдэх асуудлыг олгох лиценз зөвшөөрлийн тоонд хязгаар тогтоох маягаар шийдэх, лиценз зөвшөөрөл олгохдоо элдэв саад хандив өгөхийг тулгах, ямар нэг бодитой шалтаг, шалтгаангүйгээр асуудлыг шийдэхгүй удаах зэрэг шууд авилгалд санаархсан хүнд сурталтай шийдвэртэй тэмцэнэ. Бизнес эрхлэхтэй холбоотой лиценз, зөвшөөрөл олгоход шаарддаг зах зээлийн зарчимд нийцээгүй хэрэгцээ, ач холбогдол багатай олон бичиг баримтыг эрс цөөрүүлэх, ялангуяа энэ чиглэлээр яам, агентлаг, нийслэл, аймаг, сум, дүүргийн өөрөө удирдах ёсны болон гүйцэтгэх засаглалын байгууллагуудаас гаргасан хуучин социалист тогтолцооны арга барилыг сэргээсэн шийдвэрүүдийг хянаж үйлчлэлийг нь зогсооно.

Татварын бодлогоор дамжуулан үндэсний баялагын өсөлтийг урамшуулах хуримтлалыг бүрдүүлэх, татвар төлөгчөө хамгаалах, үндэсний компаниуд томорч олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх боломж олгоход анхаарна. Татварын бодлогыг зөвхөн улсын төсөв бүрдүүлэхэд чиглүүлэх явцуу хүрээнээс гаргаж, эдийн засаг нийгмийг хөгжүүлэхэд аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн сонирхлыг төрүүлж чадахуйц хүчтэй механизм болгон ашиглах системтэй, стратегийн зорилттой бодлого явуулан татварын ачааллыг бууруулж, татвар төлөгчдийн хүрээг тэлэх замаар бизнесийг дэмжинэ.

Архи тамхины онцгой албан татварын хуулийн хэрэгжилт, архи тамхины үйлдвэрлэл, импортод хатуу хяналт тогтоож төсвийн орлогыг зохих ёсоор бүрдүүлнэ. Малчин өрхийг бүх төрлийн татвараас 5 жилийн хугацаатай чөлөөлнө. Импортын татварыг бууруулж, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ялгавартай тогтооно. Аж ахуйн нэгжийн татварыг аажмаар нэг шатлалтай болгоно. Шинэ техник, технологийн хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлнө.

Татварын өршөөл зарлаж бүртгэл, мэдээллийн асуудлыг цэгцэлнэ. Татварын байцаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх бөгөөд ажлын гүйцэтгэлд нь өндөр шаардлага тавих болно. Татварын хураамж төлж байх

хэлбэрийг жижиг бизнесийг дэмжих, тэднийг татвараар дарамтлахгүй байх хэрэгсэл болгон ашиглана.

Гаалийн үйлчилгээг шуурхай, хүнд сурталгүй болгоно.

Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж, ялангуяа үйлдвэр, хөдөө аж ахуйд оруулах гадаадын хөрөнгө оруулалтыг 3 дахин нэмэгдүүлнэ.

Жижиг бизнес эрхлэх нь айл өрх болон хувь хүмүүсийн өөдлөхийн эхлэл болдгийг иш үндэс болгон төрөөс дэмжинэ. Бизнесийг захиргааны элдэв дарамтаас чөлөөлж айл өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. Гэр бүлд очих "Итгэлийн мөнгө" хөдөө орон нутагт жижиг бизнес хөгжих таатай нөхцөл бүрдэнэ.

Иргэд, залуучуудад бизнес эрхлэхэд нь туслах зорилготой бизнес арилжаа мэдээллийн төвүүдийг аймаг бүрт байгуулахыг дэмжинэ. Иргэдийн гар урлалын бүтээгдэхүүн, соёлын уламжлалт эд зүйлсийг олон улсын зах зээлд борлуулах бололцоог бий болгоно. Үндэсний оюуны үнэт баялгийг олон улсын эрх зүйн хамгаалалтанд оруулж гар урлалын үйлдвэрлэлийг хөгжуулнэ. Гар урлал, бэлэг дурсгал, соёлын эд зүйлсийн худалдааны цар хүрээг экспортын чухал салбар болтол хөгжүүлнэ.

Иргэдийн бизнесийн чөлөөт өрсөлдөөнийг тууштай дэмжиж зохицуулалтыг нь боловсронгуй болгоно.

Салбарын мэргэжлийн холбоодтой Засгийн газраас харилцах байнгын механизм бий болгон дэлхийн зах зээлд гарах талаар хамтарч ажиллана.

Улаанбаатар төмөр зам, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр мэтийн том үйлдвэрийг түшиглэсэн хувийн жижиг үйлдвэрүүдийн сүлжээ бий болгох бодлого явуулна.

Жижиг дунд үйлдвэрийг татвар, гааль, банк санхүүгийн үйлчилгээгээр дэмжихдээ хөгжингүй улс орнуудын нийтлэг жишиг, менежментийн ололтыг удирдлага болгоно. Эх орны түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгон экспортлох үйлдвэрүүдийг дэмжинэ. Монголын үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд таниулах, худалдаалах зорилгоор олон улсын үзэсгэлэн яармагт оролцох, сурталчилгаа явуулахад туслана.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж чанарын үзүүлэлтүүдийг сайжруулан дэлхийн зах зээлд гарах нөхцлийг бий болгон монголын хөдөөг дэлхийн эдийн засагтай холбох зорилт тавьж байна. Органик бүтээгдэхүүний гэрчилгээг мах, сүүн бүтээгдэхүүнд олгож бага хэмжээний бүтээгдэхүүнийг өндөр үнээр зарах чадвартай бизнесийг дэмжинэ. Гоц гойд чанартай шилмэл омгийн амьтад,

зөвхөн Монголын нутагт байдаг загасны махыг зорилтот зах зээл бий болгон борлуулах бизнесийг дэмжинэ. Ноолуурын үнийг хэт бууруулахын эсрэг төрийн зохицуулалт хийнэ. Түүхий ноолуурын дотоодын үнийг 30 мянган төгрөгөөс бууруулахгүй.

Байгаль, цаг уурын өөрчлөлт ихээр явагдаж байгаа өнөөгийн нөхцөлд уламжлалт мал аж ахуй эрхлэлтийг эрчимт хэлбэрт оруулахад анхаарна. Фермерийн аж ахуйг дэмжих тусгай хөтөлбөр гарган ажиллах болно. Мал аж ахуйн бүтээгдэхүүний эмнэлэг, ариун цэврийн хяналт, үйлчилгээний шаардлагыг өндөржүүлж дотоод, гадаадын зах зээлд борлогдох нөхцлийг бүрдүүлнэ.

Бага талбайгаас их ургац хураах чиглэлийг баримтлан бодлогоор дэмжинэ. Олон төрлийн үр өгөөжтэй, байгалийн эрс тэс нөхцөлд тэсвэртэй, болц түргэнтэй таримал үр, сортыг газар тариалангийн салбарт нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

Монгол улсын нутаг дэвсгэрт буй ашигт чанар нь мэдэгдсэн, эмчилгээ болон хүнсний зориулалтаар хэрэглэгддэг эмийн болон ховор ургамал, ургамлын төрөл зүйлийг хамгаалахад анхаарч, таримал байдлаар үржүүлж ашиг орлого олох боломжийг иргэдэд олгоно. Зөгий, гахай, загас, тахиа болон бусад шувуу өсгөж үржүүлэх иргэдийн бүхий л санаачилгыг дэмжиж элдэв зөвшөөрөл, хүнд суртлаас чөлөөлнө.

Мэргэжлийн сургалтын байгууллагуудыг дэмжиж залуу хүн бүр тусгай мэргэшил дадлагатай болж бие даан амьдрах чадвартай болох, зах зээлийн өрсөлдөөнд ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжийг олгоход анхаарна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх тусгай хөтөлбөрүүдийг үр дүнтэйгээр хэрэгжүүлнэ. Жил бүр 20-30 мянган ажлын байр шинээр бий болгоно.

11. Бүтээн байгуулалт, эрчимтэй хөгжил

Эрчим хүчний үйлдвэрлэлийг эрчимжүүлэхэд онцгой анхаарна. Эрчим хүчний хэрэглээг айл өрх бүрт хүргэх ажлыг түргэвчлэнэ. Төвийн эрчим хүчний системд шаардлагатай аймаг, сумын төвүүдийг холбох ажлыг үргэлжлүүлэх болно. Хувийн компаниудын үйлдвэрлэсэн эрчим хүчийг Төвийн эрчим хүчний системийн хүрээнд борлуулах боломжтой болгоно. Цахилгаан эрчим хүчний хараат байдлаас ангижрах зорилго тавьж ажиллах юм.

Нар, салхи, усны сэргээгдэх найдвартай эх үүсвэрийг өргөн дэлгэрүүлнэ. “Ардчилсан холбоо” эвслийн засаглалын үед санаачлан

эхлүүлсэн “100000 нарны гэр хөтөлбөр”-ийг бүрэн хэрэгжүүлж дуусгана. Хот суурин газарт айл өрхүүд сэргээгдэх эрчим хүч ашиглах явдлыг урамшуулан дэмжинэ.

Жижиг, дунд оврын УЦС-ыг барихад дэмжлэг үзүүлнэ.

Байгалын хийг ашиглахад онцгой анхаарч дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

Газрын тосны хайгуул, олборлолтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарна.

Төмөр замыг хүн амын нягтралын орчин болгон анхаарч нэвтрүүлэх чадвар, техникийн түвшинг сайжруулахын зэрэгцээ төмөр зам дагуух тосгон суурин газруудын нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

Олон улсын болон дотоодын тээвэрт авто тээврийн хэрэгслээр гүйцэтгэх (төвийн бүс нутаг, хөдөө газар) ажлыг төрөөс идэвхтэй дэмжинэ.

Агаарын тээврийн салбарыг ирээдүйтэй хэмээн үзэж түлхүү хөгжүүлнэ. Хувийн авиа компаниудыг дэмжинэ.

Тив хоорондын агаарын тээврийн гаалийн баталгаат агуулахуудыг Монголд байгуулж бараа бүтээгдэхүүнийг татваргүй худалдаалах олон улсын бүсийг бий болгоно.

Зам гүүр барих ажлыг эрчимжүүлж тендер сонгон шалгаруулалтанд хатуу хяналт тавьж, мөнгө хөрөнгө зориулалтын дагуу үр ашигтай зарцуулагдах явдлыг баталгаажуулна. Босоо, хэвтээ тэнхлэгийн зам барих ажлыг үргэлжлүүлж олон улсын авто замын сүлжээнд холбогдох чиглэлээр ажиллах болно.

Улаанбаатар хотод гудамж талбайн замын хөдөлгөөний бөөгнөрөл, түгжрэлийг арилгахын тулд холбогч болон дамжин өнгөрөх замууд, замын дагуух зогсоолуудыг бариулж замын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.

Цахилгаан болон хөдөлгөөнт холбооны салбарт шинэ өрсөлдөгчид орж ирэхийг дэмжинэ. Монголын цахилгаан холбооны салбарт өрсөлдөөн бий болох нөхцлийг бүрдүүлнэ. Хөдөлгөөнт холбооны гуравдагч сүлжээг бий болохыг дэмжинэ. Одоо байгаа үйлчилгээ үзүүлэгчид хэрэглэгчдийн эрх ашгийг хохироохгүй байх явдлыг баталгаажуулна. Сансрын хөдөлгөөнт холбооны системийг өргөнөөр ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.

12. Мөнгө, санхүү

Төсөв санхүүгийн бодлогыг нийгмийн шинэ бодлогыг хэрэгжүүлэхэд зохицуулан шинэчлэнэ. Төсвийн зарлагын бүтцийг оновчтой болгож,

хүүхдүүдэд "Итгэлийн мөнгө" олгох "Монголын ирээдүй" төрийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлнэ. Төсвийн хөрөнгөөр тансаг хэрэглээ бүрдүүлдэг зардлыг зогсоож, орлогын бүрдэлт, зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулна. Төрийн удирдлагын албыг чадварлаг цомхон болгож хэмнэлттэй ажиллуулна. Банк санхүүгийн байгууллагуудаар дамжуулан төрийн санхүүгийн үйлчилгээг иргэдэд ойртуулж захиргааны зардлыг хэмнэнэ. Төсвийн мөнгө хөрөнгөөр бие биедээ тал засах, бэлэг сэлт худалдаж авах явдлыг болиулж, цалин урамшуулал шударгаар олгогддог, санхүүгийн бүртгэл тайланд үнэн зөв тусгагддаг байх явдлыг баталгаажуулна. Төсвийн зарлагын хяналтын комисс байгуулж ажиллуулна.

Орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлж, төсвийн байгууллагуудын санхүүгийн бие даасан байдлыг хангана.

Банк санхүүгийн эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгоно. Олон улсын гэмт бүлэглэлүүд, алан хядах байгууллагуудын мөнгийг угаасан, улсын өмч хувьчлалын ажилтай хутгалдуулсан гэх хэргүүдийг нягтлан шалгаж хуулийн дагуу шийдвэрлэнэ. Банкны зээлийн хүүг бууруулж эдийн засгийн эрчимтэй үйл ажиллагаа явуулах бололцоог иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгоно.

Хувьчлалын ажлыг үргэлжлүүлэх ба өмч хувьчлалын ажилд гарч буй алдаа дутагдлыг засаж сайжруулна. Зарим томоохон аж ахуйн хувьчлалын гэмт хэргийн шинжтэй гажуудлыг хууль хяналтын байгууллагуудаар шалгуулж зохих шийтгэлийг ногдуулна. Нийгмийн буюу менежментийн хувьчлалыг шударгаар явуулна.

Хөрөнгийн зах зээлийг төлөвшүүлэхэд анхаарна. Хөрөнгийн зах зээлийн арилжаа, дотоод мэдээллийн солилцоонд тавих хяналтыг төгөлдөржүүлнэ. Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг сэргээн идэвхжүүлнэ.

13. Ажил эрхлэлт, эрх тэгш харилцаа

Засгийн газар, ажил олгогч эздийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн гурван талт нийгмийн зөвшилцлийн механизмыг улам хөгжүүлж, энэ харилцаан дахь төрийн хариуцлагыг дээшлүүлж, ёс төдий байдлаас гарган төр засгийн хүлээсэн үүргийг чанд биелүүлнэ.

Ажил олгогч эздийн байгууллагаас гишүүдийн хүсэлтийн дагуу байгуулан ажиллаж байгаа "Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн интернэт сүлжээ"-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хөдөлмөрийн харилцаанд хүйс, нас, үзэл бодол, хөрөнгө чинээ, нийгмийн байдлаар ялгаварлан гадуурхах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх зэрэг ноцтой зөрчлийг таслан зогсооно. Хөдөлмөрийн

хууль тогтоомжийг зөрчсөн, үйлдвэрлэлийн осол гаргаж хүний амь нас хохироосон гэм буруутай этгээдэд хүлээлгэж буй хуулийн хариуцлагыг чангатгах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, мэргэжлийн нөхөн сэргээлт, нийгмийн түншлэлийн харилцааны хууль эрхийн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрт өөрчлөлт оруулан үр ашигтай хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ. Хөдөө орон нутгийн иргэд, 8, 10 дугаар анги төгсөөд хөдөлмөрийн зах зээлд шилжигсэд, ахимаг насны ажилчин, албан хаагчид зэрэг хүн амын тодорхой хэсэг, бүлэгт хандсан хөдөлмөр эрхлэлтийн зорилтот хөтөлбөрүүд, албан бус хэвшилд ажиллагчид, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах төсөл, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

Мэргэжлийн боловсрол олгох сургалтыг үйлдвэрлэл дээрх сургалттай хосолсон мэргэжилтэй ажилчид бэлтгэх тогтолцоо бий болгон хөгжүүлнэ.

Гадаадад хөдөлмөр эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах талаарх олон улсын конвенцид нэгдэн орох чиглэлээр ажиллана.

14. Байгаль орчин, тулхтай хөгжил

Байгаль хамгаалалтын ажилд иргэдийн оролцоог чухалчилна. Олон улсын чиглэлээр хэрэгжиж буй төслүүдийн үр өгөөжийг дээшлүүлэх, үнэлэх талаар дорвитой арга хэмжээ авна. Ховордсон ан амьтан, шувууг хамгаалах өсгөн үржүүлэх ажилд анхаарал тавина. Байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахын тулд биологийн аргаар хортон мэрэгч, шавьжтай тэмцэхийг чухалчилна.

Цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ. Одоогийн байдлаар олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй судалгаа туршилтын ажлын үр дүнд үндэслэн цөлжилттэй тэмцэх ажлыг бүрэн хэмжээгээр эхлүүлэх болно. "Түйрэнтэй тэмцэх нь" хамтын ажиллагааны хөтөлбөрийг Япон, Хятад, Солонгос, АНУ, Канад зэрэг улсуудтай хамтран бий болгож, хэрэгжүүлнэ. Ургамал хамгаалал, эрүүл ахуйн стандартын хяналтын шаардлагыг дээшлүүлнэ.

Агаарын бохирдолтой тэмцэх зорилгоор шинжилгээг тогтмолжуулж, бохирдлын эх үүсвэрийг багасгах чиглэлээр дорвитой ажил зохионо. Хатуу түлшний боловсруулалтыг сайжруулж хорт бодисуудыг нь ялгаж шахмал түлш үйлдвэрлэх, хэрэглэх явдлыг дэмжинэ. Усны эхийг хамгаалах, ус руу хог хаягдал, бохир ус хийх явдалд хатуу хяналт тогтооно. Усны чанарын шинжилгээг орон нутаг бүрт тогтмолжуулна. Газрын гүний усыг бохирдуулж болзошгүй аливаа үйлдлийг таслан зогсооно. Байгальд удаан задардаг ба химийн хорт хаягдлаар хөрсийг бохирдуулж буй байдалтай хатуу тэмцэнэ.

Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг байгуулах ажлыг түргэтгэнэ. Хог хаягдлыг ангилан боож ялгах анхан шатны ажлыг албан хөдөлмөр эрхлэлт болгож цалин хөлс олгож эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд ажиллуулах замаар шийдвэрлэнэ. Хот суурин газар хогны савны тоо хэмжээг ихэсгэнэ. Хог хаягдалтайгаа харьцах иргэний соёлыг дээшлүүлэхэд анхаарна.

Хамгийн сүүлийн үеийн өргөн хэрэглээний, экологийн бохирдол багатай Автомашиныг оруулж ирэх явдлыг гааль, татварын бодлогоор дэмжинэ. Түлш шатахууны найрлаганд хортой элемент бага байлгах стандартын шаардлагыг мөрдүүлнэ. Автомашины утааны гаралтад хязгаарлалт тогтооно.

Уул уурхайн ашигт малтмалын ордуудыг ашиглахдаа хүн амын ахуй амьдралыг сайжруулах зорилтыг шийдвэрлэхэд чиглүүлнэ. Ашигт малтмалын орд газрын хайгуулын болон ашиглалтын лицензийн журмыг өөрчилж хялбаршуулан уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжих таатай нөхцлийг бүрдүүлнэ. Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн зүгээс байгаль орчны нөхөн сэргээлт хийх явдлыг баталгаажуулна.

Ашигт малтмалын орд газар, нутаг дэвсгэрийг гадаад орон, олон улсын компаниудад түрээслэн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.

Олон улсын гэрээ хэлэлцээрийн дүнд далайд гарцгүй орнуудад олгогдсон тодорхой эрхүүдийг үр дүнтэй ашиглах талаар идэвхтэй ажиллана. Далайн баялгийг ашиглах зорилгоор хөрөнгө оруулах явдлыг дэмжинэ. Хөлөг онгоцны бүртгэлийн ажлыг олон улсын дээд зэрэглэлийн үйлчилгээтэй болгоно.

Тав. Даяаршсан ертөнцөд итгэлтэй амьдарцгаая.

15. *Тэнцвэртэй, давшингуй гадаад бодлого*

Өөрийн орны иргэний эрх ашгийг дэлхийн аль ч өнцөг буланд хамгаалж явдаг гадаад бодлогын нэн чухал зарчим өдөр тутмын үйл ажиллагааны чиглэл байх болно.

Хүн амын ахуй амьдралыг сайжруулах үндсэн зорилгод нийцүүлэх гадаад бодлогыг илүү прагматик, давшингуй болгоно. Зүүн хойд Азийн яриа хэлэлцээнд идэвхтэй оролцоно.

Гадаад бодлогод эдийн засгийн болон улс төр, соёлын харилцааг чухалчлах бөгөөд дипломат албанд мэргэжлийн ур чадвартай хүмүүсийг ажиллуулах шалгуурыг хатуу мөрдөнө.

Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын ажилд стандартын шаардлагыг өндөрсгөж, зочид буудал, үзвэр үйлчилгээний газар, жуулчны бааз барих байгууллагуудад зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ. Олон улсын жуулчны үйлчилгээ үзүүлэгч компаниудын салбарууд Монголд байгуулагдах, өндөр хөгжилтэй орнуудаас ирэх жуулчдыг авчирч аялуулах ажилд туслана. Аялалын шинэ чиглэл, маршрутыг гаргахад төрийн зүгээс анхаарч шаардлагатай хөрөнгө оруулалтыг хувийн бизнесийнхэнтэй хамтарч хийнэ. Дунд болон бага орлоготой жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор тэдний хэрэгцээ сонирхолд нийцсэн үйлчилгээг бий болгоход анхаарна. Тээвэр бусад дэд бүтцийн үйлчилгээг жуулчны аялалын чиглэлийн дагуу байгуулах, тогтвортой ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ. Монголын байгалийн үзэсгэлэнт газруудад өндөр настны сувиллын газрууд, олон улсын амралтын хотхонуудыг бий болгох санаачилгыг дэмжинэ.

БНСУ-ыг Монголын хөгжлийн жишиг орон болгон авч үзэж улс орны эдийн засаг, ахуй амьдралын гол үзүүлэлтүүдийг эдгээр орнуудтай жишин харьцуулж үнэлж байх болно.

Улс үндэснийхээ тусгаар тогтнолыг бататган бэхжүүлэхийн хамт хөрш орнууд, олон улсын зах зээлийн боломжийг илүүтэй ашиглах, хамтран ажиллах бодлого баримтална.

16. Зэвсэгт хүчин, аюулгүй байдал

Батлан хамгаалах салбарт “Энхийг сахиулах зэвсэгт хүчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Зэвсэгт хүчнийг олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд өргөн бүрэлдэхүүнтэй оролцох чадвартай болгон бэхжүүлж хилийн чанадад гүйцэтгэх үүрэг, ажлыг нь нэмэгдүүлэхэд энэ хөтөлбөр чиглэгдэнэ.

Улсын хил хамгаалалтын ажилд онцгой анхаарал хандуулж “Дархан хил” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Улсын хил хамгаалах хүчний техник хэрэгслийн хангалтыг сайжруулна. Хил хамгаалалтанд сансрын холбоо, тоон мэдээллийн технологийг өргөн ашиглана. Хил хамгаалагчдын шилжилт хөдөлгөөн хийх чадварыг эрс нэмэгдүүлж, тусгай зориулалтын техник хэрэгслийн хангалтыг сайжруулна. Хүний нөөцийн хөгжилд онцгой анхаарч, хилчдийн ахуй амьдралыг дээшлүүнэ. Улсын хил хамгаалалтанд орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор хилийн хязгаар нутагт амьдарч буй иргэдэд төрийн нийтлэг үйлчилгээг хүргэхэд түлхүү анхаарах болно.

Байгалийн болон хүний үйл ажиллагааны уршгаас бий болсон гамшиг аюулыг урьдчилан сэргийлэх, арилгах ажилд анхаарал хандуулж мэдээлэл, харилцаа холбооны оновчтой бүтэц, үйл ажиллагааны журмыг бий болгоно. Тусгай үүрэгтэй иргэний хамгаалалтын ангиудын техник хэрэгслийн хангалт, хүн хүчний бэлтгэл хангамжид онцгой анхаарал хандуулна. Халдварт

өвчнийг эсэргүүцэх эм тарилга, вакцины нөөцийг зохих түвшинд бүрдүүлж хүн амд тараах хамгаалалтын тусгай хэрэгслийн хангалтыг хийнэ.

Тагнуулын албыг өндөр мэргэшилтэй албан хаагчдаар бүрдүүлэхэд анхаарч, гүйцэтгэх ажлын шилдэг техник хэрэгсэл, аргыг нэвтрүүлнэ. Тагнуулын алба улс төрийн зорилгод үйлчилдэг байдлыг таслан зогсооно. Улс орны аюулгүй байдалд ноцтой хохирол учруулсан бөгөөд улс төрийн шалтгаанаар дарагдаж замхарч буй ноцтой хэргүүдийг нягтлан шалгана.